

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/06


Арвайхээр

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх, хариуцлагатай жижүүр
томилох тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/93 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.
2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах шуурхай штаб байгуулж, 24 цагаар ажиллах хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, мэдээг өдөр бүр 18 цагт аймгийн Онцгой байдлын газарт, 7 хоног бүрийн баасан гарагт 17.30 цагаас өмнө Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт бичгээр болон цахимаар, шаардлагатай тохиолдолд тухай бүр мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров)-д даалгасугай.
3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед 24 цагаар ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед албан хаагчдад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чөлөө олгохгүй байх, холбоо барих утсыг байнга нээлттэй байлгахыг Удирдлага, төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа)-д даалгасугай.
5. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах үед хариуцсан ажилдаа идэвх зүтгэл гарган үр дүнтэй ажилласан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах, эрх, үүргийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх саналыг нэгтгэн Эрүүл мэндийн газрын даргад танилцуулж, шийдвэрлүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Захиргаа, нийтлэг үйлчилгээний алба (Б.Валя) нарт тус тус даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

018900016


ЭМГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын
12-ны өдрийн 4/16 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ИЮЕ0007

ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД 24 ЦАГААР
АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Овог нэр	Албан тушаал	Хугацаа	Холбоо барих утасны дугаар
1	Ю.Ичинноров	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга	2-р сарын 17	99038205
2	М.Золзаяа	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга	2-р сарын 18	88108948
3	Н.Оюунтуяа	Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга	2-р сарын 19	89810101
4	Я.Жаргал	Хяналт шинжилгээ, мэдээллийн хэлтсийн дарга	2-р сарын 20	99051828
5	С.Дуламсүрэн	НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн	2-р сарын 21	99028329
6	Ж.Болзол	УТХ-ийн ахлах мэргэжилтэн	2-р сарын 22	99917149
7	Н.Төгс-очир	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 23	88324000
8	Д.Нацагням	Статистик, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 24	99668055
9	С.Эрдэнэчулуун	Яаралтай, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 25	88443338
10	Ц.Сонинбаяр	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 26	88011900
11	Ө.Баярдулам	Уламжлалт, анагаах ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 27	80988260
12	Н.Дэжидням	Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 28	88511003
13	С.Энхцэцэг	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хариуцсан мэргэжилтэн	2-р сарын 29	99049154
14	Б.Долзодмаа	Халдварт өвчний мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтан	3-р сарын 01	88715577
15	Э.Дуламсүрэн	Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн	3-р сарын 02	94771868

ЭМГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын
17-ны өдрийн 4/16 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан гарсан тушаал шийдвэр, холбогдох журам, заавартай танилцан, мэдээллийг бусдад түгээх
2. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас хавсралт маягтуудын дагуу мэдээ авч, нэгтгэн, дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.
3. Өмнөх өдрийн жижүүрээс авсан мэдээллүүдийг 12 цагт ЗӨСҮТ, 13 цагт НЭМҮТ-д тус тус мэдээлэх
4. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан зөвлөмж, видео бичлэгүүдийг НЭМҮТ-ийн мэдээлэл харилцааны групп, ЭМЯ болон ХӨСҮТ-ийн цахим болон фэйж хуудаснаас авч, байгууллагын фэйж хуудаст байршуулан, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах
5. ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвөөс тухайн өдөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг авч нэгтгэн, аймгийн Онцгой байдлын газрын шуурхай штабын 70322855 утсаар 18:00 цагт мэдээлж, илтгэх хуудсыг цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэх
6. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан хэрэгжүүлж буй ажлын тайланг эрүүл мэндийн байгууллагуудаас авч долоо хоног бүрийн баасан гарагт 17.30 цагаас өмнө Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт бичгээр болон цахимаар хүргүүлнэ.
7. Холбогдох цаг үеийн шуурхай мэдээ, мэдээллийг байгууллагын удирдлагат яаралтай мэдээлэх
8. ЭМЯ болон холбогдох бусад байгууллага, аймаг, орон нутгийн удирдлагуудаас өгсөн үүрэг чиглэлийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж, тайлагнах
9. Байгууллагын ажлын байр, албан өрөө тасалгаа, бусад хэсгийн гал, ус, цахилгааны аюулгүй байдлыг хангаж ажиллах
10. Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн байдал, холбоо барьсан хүмүүс, ирсэн мэдээ, мэдээлэл, түүнийг шийдвэрлэсэн болон цаашид анхаарах асуудлын тухай дэлгэрэнгүй тайлан бичиж, гарын үсгээр баталгаажуулан дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.